Сувилагч нарын эмнэл зүйн практик ур чадвар, цогц чадамжийн хэрэгцээг тодорхойлох судалгаа

Б.Азжаргал[1], Д.Энхтуяа[2], Ж.Сэргэлэнцэцэг[1], Ю.Уранчимэг[3], Д.Нямсүрэн[3], Шикако Сугавара[4], Г.Ганхуяг[1]

[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль
[2]АШУҮИС, Мэргэжил дээшлүүлэх институт
[3]Монголын сувилагчийн нийгэмлэг
[4]ОУ-ын ЖАЙКА байгууллага
Цахим шуудан: azjargal.b@mnums.edu.mn, Утас: 99102855

Түлхүүр үг:
Чадамж
Ур чадвар
Эмнэл зүйн ур чадварын шатлал

Товч утга:
Үндэслэл: Мэргэжилтний цогц чадамж нь мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг үнэлэх, сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, хүний нөөцийг хөгжүүлэх, сургалтын хөтөлбөр боловсруулах, ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгоход тулгуур болдог. **Зорилго:** Сувилагч нарын эмнэл зүйн практик ур чадварын шатлал, цөм чадамжийг тодорхойлох. **Арга, аргачлал:** Судалгааг явуулахдаа аналитик судалгааны агшингийн загварыг ашиглан Монгол улсын хэмжээнд ажиллаж буй 495 сувилагч нарыг санамсаргүй түүврийн аргаар сонгон Google Form платформийг ашиглан Япон улсын сувилагчийн нийгэмлэгийн эмнэл зүйн практак ур чадварын шатлал, цөм чадамжийн үзүүлэлтийг ашиглан 5 бүлэг 83 асуумжаар мэдээллийг цуглуулав. **Үр дүн:** Эрэлт хэрэгцээг олж харах чадвар, сувилах ур чадвар, хамтран ажиллах чадвар, шийдвэр гаргах чадвар тодрхойлогдож, мэргэжлийн зэрэг нь цогц чадамжтай хамааралтай байна. **Дүгнэлт:** Монгол улсад сувилагч нарын төгсөлтийн сургалтын хөтөлбөрийг чадамжид суурилан боловсруулах, эмнэл зүйн практик ур чадварын шатлалыг мэргэжлийн зэрэгтэй уялдуулан хөгжүүлэх хэрэгцээтэй байна.

Үндэслэл: Сувилахуйн практик цөм чадвар хоорондоо уялдаатай, сувилагчийн ёс зүйг чандлан сахидаг, сувилахуйн мэргэжлийн ур чадварт тулгуурлан үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тулгуурлан сувилахуйн тусламж үзүүлэх чадвар юм. Мэргэжилтний цогц чадамж нь мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг үнэлэх, сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, хүний нөөцийг хөгжүүлэх, сургалтын хөтөлбөр боловсруулах, ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгоход тулгуур баримт бичиг болдог[1]. Монгол улсад анх сувилагч бэлтгэх төгсөлтийн өмнөх сургалтанд ашиглах сувилагч мэргэжилтний цогц чадамжийг 2016 онд боловсруулан, АШУҮИС-ийн эрдмийн зөвлөлөөр батлуулан, сургалтын хөтөлбөр боловсруулан ашиглаж байна[2].

АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийг сувилагч мэргэжилтнээр төгсөгч нь үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлдэг, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг дээдлэн ажилладаг, өөрийн ажилдаа шинэ технологийг ашигладаг, судалгаанд суурилсан тусламжийг аюулгүй байдлаар үзүүлдэг, мэргэжил нэгт нөхдөө манлайлагч, багаар хамтран ажиллах чадвар бүхий цогц чадамж эзэмшсэн байна хэмээн тухайн баримт бичигт дурдсан байна[2].

Япон улсын сувилагчийн нийгэмлэг болон бусад судлаачдын судалгааны үр дүнд[3-12] эмнэл зүйн практик ур чадварын шатлал, цогц чадамжийн үзүүлэлтийг боловсруулан сувилагчийн цогц чадамжийг төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөртэй уялдуулан сайжруулах хэрэгцээ шаардлага байна. Монгол улсад сувилагчийн төгсөлтийн дараах цогц чадамжийн баримт бичиг үгүй, чадамжид суурилсан хөтөлбөр хэрэгжээгүй байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болж байна.

Зорилго: Сувилагч нарын эмнэл зүйн практик ур чадварын шатлал, цөм чадамжийг тодорхойлох зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

Зорилт:
1. Цогц чадамжийн хэрэгцээг тодорхойлох
2. Хүчин зүйлсийн эмнэл зүйн практик ур чадварын шатлал, цөм чадамжийн хамаарлыг тогтоох

Арга, аргачлал: Судалгааг явуулахдаа аналитик судалгааны агшингийн загварыг ашиглан Монгол улсын хэмжээнд ажиллаж буй 495 сувилагч нарыг санамсаргүй түүврийн аргаар сонгон Google Form платформийг ашиглан Япон улсын сувилагчийн нийгэмлэгийн эмнэл зүйн практак ур чадварын шатлал, цөм чадамжийн үзүүлэлтийг ашиглан 5 бүлэг 83 асуумжаар мэдээллийг цуглуулав. Асуумжийг Ликертийн 5 оноогоор 1 хариултыг (1-огт зөвшөөрөхгүй, 2-зөвшөөрөхгүй, 3-мэдэхгүй, 4-зөвшөөрнө, 5-бүрэн зөвшөөрнө) сонгосон. Нэг асуултанд хариулаагүй 7 оролцогчийг судалгаанаас хасах шалгуурын дагуу хассан болно. Судалгааны үр дүнгийн хүснэгт, дүрслэлийг Microsoft office 2016 иж бүрдэл, статистик боловсруулалтыг SPSS-25 программаар мэдээ мэдээллийн өгөгдлийг кодлон шивж, алдааг шалган, тоон мэдээллийг боловсруулав. Үл хамааралт хувьсагчдыг шатлан сонгох аргаар олон хүчин зүйлийн регрессийг тооцсон ба P утга 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистикийн үнэн магадлалтай гэж үзсэн. Асуумжийн дотоод зохицол, найдвартай байдлыг Кронбах альфа коэффицентээр үнэлэхэд 0.94 байна. Түүвэрлэлийн зохистой хэмжээг Kaiser-Meyer-Olkin-ий индексээр үзэхэд 0.939, хүчин зүйл хоорондын ялгааг Bartlett Sphericity Chi Square индексээр үзэхэд 3931.58, P<.000 тодорхойлогдов.

Үр дүн: Судалгаанд нийт 308 сувилагч оролцсон.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Үзүүлэлтүүд	Тоо	Хувь
Хүйсийн байдал		
Эрэгтэй	6	1.5%
Эмэгтэй	382	98.5%
Ажилласан жил		
1-5 жил	99	25.5%
2-10 жил	79	20.4%
11-15 жил	72	18.6%
16-20 жил	26	6.7%
21-25 жил	24	6.2%
26-30 жил	37	9.5%
31-ээс дээш	51	13.1%
Боловсролын байдал		
Магистр	24	6.2%
Бакалавр	207	53.4%
Диплом	157	40.5%
Мэргэжлийн зэрэг		
Зөвлөх зэрэгтэй	11	2.8%
Тэргүүлэх зэрэгтэй	47	12.1%
Ахлах зэрэгтэй	81	20.9%
Зэрэг үгүй	249	64.2%
Эмнэлгийн байгууллага		
Сувилахуйн сургууль	4	1.0 %
Улсын төв эмнэлэг	43	11.1%
Дүүргийн нэгсэн эмнэлэг	88	22.7%
Аймгийн нэгдсэн эмнэлэг	47	12.1%
Өрхийн эрүүл мэндийн төв	84	21.6%
Сургалтын эмнэлэг	1	0.3%
Бусад	121	31.2%
Бүгд	388	100%

Хүснэгтээс харахад хүйсийн хувьд эмэгтэй 98:5%, бакалаврын зэрэгтэй сувилагч 53.4%, зэрэг үгүй сувилагч 64.2%, бусад эмнэлгийн сувилагч нараас 31.2% байгаа нь зонхилох үзүүлэлт болсон байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 2. Цогц чадамжийн хэрэгцээ тодохойлогдсон байдал

Эмнэл зүйн практик ур чадвар, цогц чадамж	Mean	SD
Эрэлт хэрэгцээг олж харах чадвар	3.59	1.03
Сувилах ур чадвар “Мэргэжлийн ур чадвар”	3.72	0.93
Хамтран ажиллах чадвар	3.79	0.93
Шийдвэр гаргах чадвар	3.90	0.92
Мэргэжлийн зэргийн хамааралт байдал	3.99	1.04

Монгол улсад сувилагч нарын төгсөлтийн сургалтын хөтөлбөрийг чадамжид суурилан боловсруулах, эмнэл зүйн практик ур чадварын шатлалыг мэргэжлийн зэрэгтэй уялдуулан хөгжүүлэх хэрэгцээтэй байна.

Хүснэгт 3. Цогц чадамжийн олон хүчин зүйлийн шинжилгээ

Үзүүлэлтүүд	B	β	SE	t	P утга
(Constant)	1.74		0.343		
Туршлага	0.23	.597b	0.015	14.6	.000
Боловсрол	0.417	.270b	0.053	5.463	.000

R=.669
R^2=.001, .448
Adjusted R^2=.443
F=.377, 103, P=.000

Хүснэгт 3-аас харахад мэргэжлийн зэрэг нь цогц чадамжтай хамааралтай болохыг харуулж байна.

Хэлцэмж: Судалгааны үр дүнгээс харахад сувилахуйн тусламж үйлчилгээнд сувилагчийн цогц чадамжийн хэрэгцээ дараах үндсэн ур чадварт тодорхойлогдсон байна[1]. Эрэлт хэрэгцээг тодорхойлох чадвар, мэргэжлийн ур чадвар, хамтрах чадвар, шийдвэр гаргах чадварыг сувилагчийн карерь хөгжилтэй уялдуулан шатлалаар хөгжүүлэх хандлага ажиглагдсан байна. Эдгээр ур чадвар нь төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг сайжруулах, шинэчлэхэд тус дөхөмтэй юм. Эдгээр чадваруудыг судлаач Г.Хулан нарын (2018) судалгааны үр дүнтэй харьцуулахад манлайлал, хүн хоорондын харилцаа, ёс зүйтэй байх, зөвлөх ур чадвар нь бидний судалгааны хамтрах чадварт хамаарагдсанаар ялгаатай боловч энэ нь чадамжид багц байдлаар тусгагдсан тул үр дүнтэй дүйж байна[2].

Канадын сувилагч нарт 119 чадвар бүхий мэргэжлийн хариуцлага, мэдлэгт суурилсан практик; ёс зүйн практик; олон нийтэд үйлчлэх; болон өөрийгөө зохицуулах зэрэг чадамжийн баримт бичиг хэрэгжиж байна[4] (2008).

Дүгнэлт:

1. Монгол улсад сувилагч нарын төгсөлтийн сургалтын хөтөлбөрийг чадамжид суурилан боловсруулах, эмнэл зүйн практик ур чадварын шатлалыг мэргэжлийн зэрэгтэй уялдуулан хөгжүүлэх хэрэгцээтэй байна.
2. Эмнэл зүйн практик ур чадварт Эрэлт хэрэгцээг олж харах чадвар, Сувилах ур чадвар "Мэргэжлийн ур чадвар", Хамтран ажиллах чадвар, Шийдвэр гаргах чадвар, Мэргэжлийн зэрэг болон туршлага, боловсролын байдал хамааралтай байна.

Талархал: Монгол улс дахь төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг сайжруулах төслийн багийн ОУ-ын ЖАЙКА байгууллагын багийн хамт олонд болон судалгаанд оролцсон нийт сувилагч нарт талархал дэвшүүлье.

Ном зүй:

1. *Мэргэжилтний цогц чадамж, АШУҮИС, Улаанбаатар хот, 2016. 3-4*
2. *Khulan Gaalan, Factors influences quality of nursing care among nurses in tertiary care hospitals, Mongolia. 2018. 40-70*
3. *Donia R Baldacchino., Journal of Clinical Nursing 15, 885–896. doi: 10.1111/j.1365-2702.2006.01643.x*
4. *Black J., Allen D., Redfern L., Muzio L., Rushowick B., Balaski B., Martens P., Crawford M., Conlin-Saindon K., Chapman L., Gautreau G., Brennan M., Gosbee B., Kelly C. & Round B. (2008) Competencies in the context of entry-level registered nurse practice: a collaborative project in Canada. International Nursing Review 55, 171–178*
5. *Verma, Sarita; Paterson, Margo; Medves, Jennifer,. Core Competencies for Health Care Professionals: What Medicine, Nursing, Occupational Therapy, and Physiotherapy Share. Journal of Allied Health, Volume 35, Number 2, Summer 2006, pp. 109-115(7)*
6. *Ko, Ja-Kyung., Modeling of Nursing Competencies for Competency-Based Curriculum Development. Volume 19 Issue 1 / Pages.87-96 / 2013 / 1225-9578(pISSN) / 2093-7814(eISSN)*
7. *Ahn, B. Y., & You, Y. M. (2012). A study on the development method of creative competency modeling with a motive of connection between development intervention and a competency profile. Korean Journal of the Learning Sciences, 6(1), 139-172*
8. *American Association of Colleges of Nursing (2010. September). Recommended baccalaureate competencies and curricular guidelines for the nursing care of older adults. Retrieved December 20, 2012, from http://www.aacn.nche.edu/. (2022.03.25)*
9. *Armstrong, G. E., Spencer, T. S., & Lenburg, C. B. (2009). Using quality and safety education for nurses to enhance competency outcome performance assessment: A synergistic approach that promotes patient safety and quality outcomes. Journal of Nursing Education, 48(12), 686-693. https://doi.org/10.3928/01484834-20091113-02*
10. *Boyatzis, R. E. (2008). Competencies in the 21st century. Journal of Management Development, 27(1), 5-2.*
11. *Choi, S. D., Kim, K. S., Jang, M. S., Chae, J. E., & Jung, K. Y. (2008). University specialization plan for higher education competitiveness research(Report No. 2008-13). Korean Educational Development Institute.*
12. *Gubrud-Howe, P., & Schoessler, M. (2008). From random access opportunity to a clinical education curriculum. Journal of Nursing Education, 47(1), 3-4. https://doi.org/10.3928/01484834-20080101-02 .*

Identification of the demand of nurse's clinical practice skill and comprehensive competenties

Azjargal B [1], Enkhtuya D[2], Sergelentsetseg J[1], Uranchimeg Y[3], Nyamsuren D[3], Shikako Sugawara[4], Ganhuyag G[1]

[1]School of Nursing, MNUMS
[2]Postgraduate training intitute, MNUMS
[3]Mongolian Nursing Association
[4]JICA organization and project team of International
E-mail: azjargal.b@mnums.edu.mn, Tel: +976-99102855

Background: Professional comprehensive competency is the fundament for evaluating professional's knowledge and skill, identifying demand of training, developing human resource and training program and improving job description.
Aim: We aimed to idenitify clinical practice skill level and core capabilities.
Materials and Methods: 495 nurses who are currently working in Mongolia, were randomly selected using an analytic research method and the data were collected through 5 groups of 83 questionnaires based on clinical practice skills and core competency of the Japanese Nursing Association using Google form.
Results: Capabilities to see demand, nursing skills, cooperating skills and decision making abilities were determined. It was identified that professional degree was associated with comprehensive competency.
Conclusion:

1. In Mongolia, there is demand to develop nursing graduate training curriculum based on competency and improve clinical practive skill level in accordance with professional degree.
2. Clinical ladder's skills include the ability to health assessment skills, nursing skills, Professional skills, Cooperation skills, Decision-making skills, professional degrees, experience, and educational degrees.

Keywords: Core competence, comptenecies, clinical ladder